



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/268

Сүхбаатар сум

Г Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6 "д", Засгийн газрын 2019 оны 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам"-ын 2.1.4, Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.4, 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймгийн Шүүх байгуулагдсаны түүхт 95 жилийн ой тохиож байгаатай холбогдуулан "Үнэнийг дэнсэлсэн он жилүүд" номыг хэвлүүлэхэд шаардагдах зардалд хөрөнгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт зарцуулагдах 4.020.000 /дөрвөн сая хорин мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.

3.Зардлын тайланг энэ оны 10 дугаар сарын 20-ны дотор гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Сэлэнгэ аймаг дахь Шүүхийн Тамгын газрын дарга /М.Нямсүрэн/-д даалгасугай.

ДАРГА Ш.ОРГИЛ

430810649